



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 836

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 148 нэрийн, нийт 9,159,366.93 (есөн сая нэг зуун тавин есөн мянга гурван зуун жаран зургаан төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Дархан-Уул аймаг дахь Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Т.Ганболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007423

37-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
836 дугаар тогтоолын хавсралт

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн балансын үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Компьютер	2017-12-12	2	1,208,350.00	2,416,700.00
2	Тог баригч	12/12/2017	5	125,290.00	626,450.00
3	Нетбук Acer Aspire v3-571	2013-10-24	1	1,099,000.00	1,099,000.00
4	Компьютер I-5	4/27/2017	1	1,484,890.00	1,484,890.00
5	Олон үйлдэлтэй хувилагч	11/7/2012	2	242,000.00	484,000.00
6	Хувилагч	11/12/2018	1	380,000.00	380,000.00
7	Компьютер	12/14/2018	1	1,336,399.93	1,336,399.93
8	Компьютер	12/14/2018	1	1,331,927.00	1,331,927.00
9	Бичгийн ширээ	12/24/2008	3	300,000.00	900,000.00
10	Сандал	6/1/2004	1	69,234.25	69,234.25
11	Сандал	1/21/2009	4	55,000.00	220,000.00
12	Сейф	6/1/2004	4	56,240.00	224,960.00
13	Сейф	6/1/2004	1	64,759.90	64,759.90
14	Сандал сургалтын	8/9/2005	3	67,500.00	202,500.00
НИЙТ ДҮН			30		9,159,366.93
					(есөн сая нэг зуун тавин есөн мянга гурван зуун жаран зургаан төгрөг ерэн гурван мөнгө)